



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/165

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 78 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн шуурхай штабын бичиг хэрэг, цахилгааны зардал, Арвайхээр сумыг бүсчлэн хаах 14 хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын түлээ, нүүрс, шатахуунд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Хяналтын постод 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 04 дүгээр сарын 11-ны өдрийг хүртлэх хугацаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчдын шатахуун, түлээ, аймгийн Онцгой комиссын шуурхай штабд хэрэглэгдэх бичиг хэргийн материалын зардалд зарцуулах 34,316,088 (гучин дөрвөн сая гурван зуун арван зургаан мянга наян найм) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100356

Аймгийн Засаг даргын 2021 оны.....
 дугаар сарын-ны өдрийн дүгээр
 захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Зэвсэгт хүчний 256-р анги	6 хүн	21 хоног	18000	2,268,000
2	Мод /шуудайгаар/	шуудай	28	5000	140,000
3	Постны моторын бензин	литр	1200	1500	1,800,000
4	Цагдаагийн газар, Онцгой байдлын газраас урьдчилан сэргийлэх ажлаар шуурхай албаны автомашинуудаар сэрэмжлүүлэг хүргэх	литр	1200	1500	1,800,000
5	Хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад шатахуун	литр	1470	1500	2,205,000
	Дүн				8,213,000
Аймгийн Онцгой комиссын шуурхай штабад хэрэглэгдэх зардал					
1	Бичгийн цаас		20 боодол	12,000	240,000
2	Телефон утасны төлбөр 80668101, 70322855, 80555101,				240,000
3	Принтерийн хор		5	50,000	250,000
4	Цэвэрлэгээний материал		1	120,000	120,000
5	Тайм Зочид буудалд тусгаарлалтад авсан хүмүүс				7,270,000
6	Богд зочид буудалд тусгаарлалтад авсан хүмүүс				7,732,900
7	Шуурхай штабын цахилгааны төлбөр				1,500,000
8	Хархорин сумын Засаг даргын Тамгын газарт ковидын зардал				5,679,000
9	Улсын Онцгой комиссын ажлын хэсгийн зардал				3,071,188
	Дүн				26,103,088
Нийт дүн					34,316,088